



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/646

Хэрлэн сум

Арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10 дугаар хуралдааны 10 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хүүхэд хөгжил, хамгааллын жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдсан үе тэнгийн дарамтыг илрүүлэх, багасгах "Үе тэнгийн дээрэлхэлтийг бууруулахад хүүхдийн оролцооны байгууллагуудын гүйцэтгэх үүрэг" нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахад 747,850 (долоон зуун дөчин долоон мянга найман зуун тавь) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний "Хүүхэд хамгаалах жилийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал"-аас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022
оны 12 дугаар сарын 20-ны
А/646 дугаар захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын төрөл	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	“Үе тэнгийн дээрэлхэлтийг бууруулахад хүүхдийн оролцооны байгууллагуудын гүйцэтгэх үүрэг” арга хэмжээний үйл ажиллагааны зардал	1	747,850	747,850
	Нийт			747,850